

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХЭА-2022/18/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Чингис хот  
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар  
Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа  
Утас: 99775390

Аудитор: Б.Хуланхатан  
Утас: 99008827

Цахим хаяг: khentii@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

<b>1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....</b>	<b>3</b>
<b>2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....</b>	<b>4</b>
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
<b>3. Аудитын тайлан.....</b>	<b>10</b>
3.1 Ерөнхий зүйл .....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Материаллаг байдал .....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	12
3.7 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
3.7.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	13
3.8 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	13
3.9 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	13
<b>4. Аудитын илрүүлэлт .....</b>	<b>13</b>
4.1. Залруулсан алдаа.....	13
4.2. Албан шаардлага.....	14
<b>5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....</b>	<b>14</b>
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
<b>6. Аудитын тайлангийн хавсралт.....</b>	<b>15</b>
6.1. Албан шаардлага 2021.02.21 №01	ХЭА-2022/18/НА-СТА-ТШЗ..... 15
6.2. Албан шаардлага 2021.02.21 №02	ХЭА-2022/18/НА-СТА-ТШЗ..... 16
6.3. Албан шаардлага 2021.02.21 №03	ХЭА-2022/18/НА-СТА-ТШЗ..... 17

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УЦУОШТ	Ус цаг уур, орчны шинжилгээний төв



## ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг

Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12

E-mail: [khentii@audit.gov.mn](mailto:khentii@audit.gov.mn)

2022.02.22 № 13

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭРДЭНЭБААТАР

023030007

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа:2021.12.31

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>142,362,872.79</b>	<b>127,317,548.20</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	234,377.68	13,800,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	200,000.00	-
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>34,377.68</b>	<b>13,800,000.00</b>
3351	Байгууллагаас авах авлага	34,377.68	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	13,800,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>142,128,495.11</b>	<b>113,517,548.20</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>109,740,159.77</b>	<b>82,327,389.40</b>
35110	Тусгай зориулалттай материал	109,740,159.77	82,327,389.40
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>32,388,335.34</b>	<b>31,190,158.80</b>
35410	Бичиг хэргийн материал	1,532,705.00	1,173,415.00
35420	Аж ахуйн материал	27,407,337.80	28,749,743.80
35440	Түлш, шатах тослох материал	3,448,292.54	1,267,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>415,241,218.95</b>	<b>358,812,253.71</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>415,241,218.95</b>	<b>358,812,253.71</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>415,175,593.53</b>	<b>358,812,253.71</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	245,463,300.00	164,177,200.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(28,078,426.92)	(20,491,605.96)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	74,907,573.78	98,907,573.78
39204	Хуримтлагдсан элэгдэл	(23,797,860.95)	(11,850,618.34)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,254,117,967.19	711,825,516.32
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,108,649,928.65)	(588,926,318.48)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,395,948.83	11,155,120.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,182,979.75)	(5,984,613.61)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>65,625.42</b>	-
39301	Програм хангамж	467,398.80	-
39302	Хуримтлагдсан элэгдэл	(467,398.80)	-
39303	Бусад биет бус хөрөнгө	525,000.00	525,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(459,374.58)	(525,000.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>557,604,091.74</b>	<b>486,129,801.91</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>6,950,179.55</b>	-
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	6,950,179.55	-
<b>413</b>	<b>Өглөг</b>	6,950,179.55	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	6,950,179.55	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>550,653,912.19</b>	<b>486,129,801.91</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>550,653,912.19</b>	<b>486,129,801.91</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,149,963,576.90	1,149,963,576.90
51101	Өмч: - төрийн	1,149,963,576.90	1,149,963,576.90
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>(719,970,103.17)</b>	<b>(784,494,213.45)</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	(719,970,103.17)	(719,970,103.17)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(64,524,110.28)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	120,660,438.46	120,660,438.46
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>557,604,091.74</b>	<b>486,129,801.91</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2021.12.31			/Төгрөгөөр/	
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,624,874,295.65</b>	<b>1,499,811,413.95</b>	
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>286,114,167.65</b>	<b>144,109,031.92</b>	
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	286,114,167.65	144,109,031.92	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	286,114,167.65	144,109,031.92	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,866,100.00	1,125,000.00	231714.43
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	283,248,067.65	142,974,031.92	31040045.001
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,338,760,128.00</b>	<b>1,355,702,382.03</b>	
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,311,337,900.00</b>	<b>1,316,761,800.00</b>	
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,311,337,900.00	1,316,761,800.00	
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>27,422,228.00</b>	<b>38,940,582.03</b>	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,гүүнгэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,500,000.00	500,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,807,728.00	7,637,712.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14,114,500.00	30,802,870.03	
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,487,040,053.37</b>	<b>1,492,430,440.83</b>	
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,487,040,053.37</b>	<b>1,492,430,440.83</b>	
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,356,584,895.07</b>	<b>1,390,336,609.46</b>	
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,006,858,379.55</b>	<b>992,681,442.91</b>	
210101	Үндсэн цалин	782,032,075.55	705,206,290.36	
210102	Нэмэгдэл	197,836,822.00	258,515,489.84	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	26,989,482.00	28,959,662.71	
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>131,289,032.08</b>	<b>127,664,048.26</b>	
210201	Тэтгэврийн даатгал	91,284,732.08	93,502,873.06	
210202	Тэтгэмжийн даатгал	10,001,100.00	8,332,119.79	
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,000,800.00	7,326,425.89	
210204	Ажилгүйдлийн даатгал	2,000,300.00	1,682,057.13	
210205	Эрүүл мэндийн даатгал	20,002,100.00	16,820,572.39	
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>27,437,830.72</b>	<b>46,147,201.00</b>	
210301	Гэрэл, цахилгаан	8,614,575.72	11,935,228.96	
210302	Түлш, халаалт	18,463,255.00	32,851,204.04	
210303	Цэвэр, бохир ус	-	1,010,768.00	
210304	Байрны түрээс	360,000.00	350,000.00	
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>16,168,447.80</b>	<b>25,999,278.41</b>	
210401	Бичиг хэрэг	1,847,295.00	2,923,288.40	
210402	Тээвэр, патахуун	11,403,867.00	10,000,592.54	
210403	Шуудан, холбоо, инжнерийн төлбөр	1,567,555.80	3,313,660.50	
210404	Ном, хэвлэл	7,400.00	-	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх ахуйн эд зүйлс	1,342,330.00	967,561.50	
210408	Бараа материал акталсны зардал	-	8,794,175.47	
2105	<b>Нормативт зардал</b>	<b>176,000.00</b>	<b>698,000.00</b>	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	176,000.00	698,000.00	
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>12,364,773.57</b>	<b>1,004,450.00</b>	
210601	Багаж, техник хэрэгсэл	6,932,893.57	869,450.00	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	2,906,480.00	-	
210604	Урсгал засвар	2,525,400.00	135,000.00	
2107	<b>Төмилөлт, зочны зардал</b>	<b>10,295,400.00</b>	<b>9,946,000.00</b>	
210702	Дотоод албан томилолт	10,295,400.00	9,946,000.00	
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>11,462,989.22</b>	<b>9,986,686.00</b>	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,064,177.42	7,101,600.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	316,800.00	1,440,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	791,960.00	779,340.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	219,350.00	206,575.00	
210805	Тээврийн хэрэгслийн оноцлогоо	66,000.00	64,300.00	
210807	Газрын төлбөр	396,000.00	394,871.00	
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,608,701.80	-	
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>140,532,042.13</b>	<b>176,389,502.88</b>	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	78,249,208.00	123,406,756.04	
210902	Хицээл үйлдвэрлэлийн дадлага хийх	403,900.00	1,500.00	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	61,878,934.13	52,981,246.84	
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>130,455,158.30</b>	<b>101,913,831.37</b>	
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>122,795,854.00</b>	<b>90,907,361.00</b>	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	122,795,854.00	90,907,361.00	
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>7,659,304.30</b>	<b>11,006,470.37</b>	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,659,304.30	11,006,470.37	
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>137,834,242.28</b>	<b>7,380,973.12</b>	
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>12,646,107.04</b>	<b>71,905,083.40</b>	
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	12,646,107.04	71,905,083.40	
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(12,646,107.04)</b>	<b>(71,905,083.40)</b>	
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>125,188,135.24</b>	<b>(64,524,110.28)</b>	

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2021.12.31

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,149,963,576.90	125,482,582.62	(849,980,382.57)	425,465,776.95
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын	-	-	4,822,144.16	4,822,144.16
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,149,963,576.90	125,482,582.62	(845,158,238.41)	430,287,921.11
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз,	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	125,188,135.24	125,188,135.24
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,149,963,576.90	120,660,438.46	(719,970,103.17)	550,653,912.19
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,149,963,576.90	120,660,438.46	(719,970,103.17)	550,653,912.19
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,149,963,576.90	120,660,438.46	(719,970,103.17)	550,653,912.19
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(64,524,110.28)	(64,524,110.28)
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,149,963,576.90	120,660,438.46	(784,494,213.45)	486,129,801.91

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2021.12.31

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>			
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,343,626,228.00</b>	<b>1,356,837,382.03</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,866,100.00</b>	<b>1,135,000.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>2,866,100.00</b>	<b>1,135,000.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,866,100.00	1,135,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,866,100.00	1,135,000.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,340,760,128.00</b>	<b>1,355,702,382.03</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,311,337,900.00</b>	<b>1,316,761,800.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,311,337,900.00	1,316,761,800.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>29,422,228.00</b>	<b>38,940,582.03</b>
131103	ЗГНХЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,500,000.00	500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,807,728.00	7,637,712.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	16,114,500.00	30,802,870.03
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,343,626,228.00</b>	<b>1,349,497,382.03</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,343,626,228.00</b>	<b>1,349,497,382.03</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,213,171,069.70</b>	<b>1,247,583,550.66</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,000,108,200.00</b>	<b>999,431,622.46</b>
210101	Үндсэн цалин	709,512,500.00	704,760,312.02
210102	Нэмэгдэл	261,094,700.00	265,711,647.73
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,501,000.00	28,959,662.71
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>131,323,409.76</b>	<b>127,629,670.58</b>
210201	Тэтгэврийн даатгал	91,319,109.76	89,546,432.31
210202	Тэтгэмжийн даатгал	10,001,100.00	9,960,150.17
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,000,800.00	7,968,119.69
210204	Ажилгүйдлийн даатгал	2,000,300.00	1,832,269.75
210205	Эрүүл мэндийн даатгал	20,002,100.00	18,322,698.66
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>27,207,425.72</b>	<b>59,947,201.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	8,614,775.72	11,935,228.96
210302	Түлш, халаалт	18,232,850.00	46,651,204.04
210303	Цэвэр, бохир ус	-	1,010,768.00
210304	Байрны түрээс	359,800.00	350,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>17,235,810.80</b>	<b>13,127,260.50</b>
210401	Бичиг хэрэг	1,601,900.00	1,278,300.00
210402	Тээвэр, шатахуун	12,558,100.00	7,819,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,344,200.80	3,314,760.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	731,610.00	714,900.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>52,500.00</b>	<b>698,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	52,500.00	698,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>6,163,528.00</b>	<b>1,019,850.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,510,588.00	806,450.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,386,240.00	-
210604	Урсгал засвар	266,700.00	213,400.00
2107	<b>Томилголт, зочны зардал</b>	<b>9,990,400.00</b>	<b>9,946,000.00</b>
210702	Дотоод албан томилголт	9,990,400.00	9,946,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>9,369,787.42</b>	<b>9,986,686.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,579,677.42	7,101,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	316,800.00	1,440,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	791,960.00	779,340.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	221,050.00	206,575.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	64,300.00	64,300.00
210807	Газрын төлбөр	396,000.00	394,871.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>11,720,008.00</b>	<b>25,797,260.12</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,316,108.00	25,465,760.12
210902	Хичээл үйлдвэрлэлийн даллага хийх	403,900.00	331,500.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>130,455,158.30</b>	<b>101,913,831.37</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>122,795,854.00</b>	<b>90,907,361.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	122,795,854.00	90,907,361.00
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>7,659,304.30</b>	<b>11,006,470.37</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,659,304.30	11,006,470.37
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>-</b>	<b>7,340,000.00</b>
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>-</b>	<b>7,340,000.00</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>7,340,000.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>-</b>	<b>7,340,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	7,340,000.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-</b>	<b>(7,340,000.00)</b>
7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-</b>	<b>-</b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>-</b>
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа:2021.12.31

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,317,261,800.00	1,307,002,450.63
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,317,261,800.00	1,307,002,450.63
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,226,354,400.00	1,216,095,089.63
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,000,108,200.00	999,431,622.46
210101	Үндсэн цалин	704,771,700.00	704,760,312.02
210102	Нэмэгдэл	265,835,500.00	265,711,647.73
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,501,000.00	28,959,662.71
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	135,014,700.00	127,629,670.58
210201	Тэтгэврийн даатгал	95,010,300.00	89,546,432.31
210202	Тэтгэмжийн даатгал	10,001,100.00	9,960,150.17
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,000,900.00	7,968,119.69
210204	Ажилгүйдлийн даатгал	2,000,200.00	1,832,269.75
210205	Эрүүл мэндийн даатгал	20,002,200.00	18,322,698.66
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	59,748,900.00	57,862,357.09
210301	Гэрэл, цахилгаан	11,246,400.00	9,850,385.05
210302	Түлш, халаалт	46,652,400.00	46,651,204.04
210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	1,010,768.00
210304	Байрны түрээс	350,100.00	350,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	6,686,900.00	6,669,760.50
210401	Бичиг хэрэг	752,000.00	740,800.00
210402	Тээвэр, шатахуун	3,519,300.00	3,519,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,696,600.00	1,694,760.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	719,000.00	714,900.00
2105	<b>Нормативт зардал</b>	698,100.00	698,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	698,100.00	698,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,021,200.00	1,019,850.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	807,800.00	806,450.00
210604	Урсгал засвар	213,400.00	213,400.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	2,561,000.00	2,561,000.00
210702	Дотоод албан томилолт	2,561,000.00	2,561,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	9,155,900.00	8,863,486.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,392,800.00	7,101,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	316,800.00	316,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	779,400.00	779,340.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	206,600.00	206,575.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	64,300.00	64,300.00
210807	Газрын төлбөр	396,000.00	394,871.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	11,359,500.00	11,359,343.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,027,900.00	11,027,843.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	331,600.00	331,500.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	90,907,400.00	90,907,361.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	90,907,400.00	90,907,361.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	90,907,400.00	90,907,361.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,317,261,800.00	1,307,002,450.63
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,316,761,800.00	1,305,867,450.63
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,316,761,800.00	1,305,867,450.63
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГА АНААС</b>	500,000.00	1,135,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500,000.00	1,135,000.00
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	86.00	86.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	79.00	79.00
620003	Үйлчлэх ажилтан	6.00	6.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021.12.31

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>38,940,582.03</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>38,940,582.03</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>38,828,461.03</b>
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>		<b>2,084,843.91</b>
210301	Гэрэл, цахилгаан		2,084,843.91
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		<b>6,457,500.00</b>
210401	Бичиг хэрэг		537,500.00
210402	Тээвэр, шатахуун		4,300,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		1,620,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		<b>5,000,000.00</b>
210604	Урсгал засвар		5,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>		<b>7,385,000.00</b>
210702	Дотоод албан томилолт		7,385,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		<b>1,123,200.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		1,123,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	<b>16,777,917.12</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		16,777,917.12
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		<b>112,121.00</b>
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		112,121.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>38,940,582.03</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>38,940,582.03</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		7,637,712.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		30,802,870.03
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Хуланхатан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 10 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Хэнтий аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн эрхэм зорилго нь “Хэнтий аймгийн нутаг дэвсгэрт ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээний хэвийн ажиллагаа, нэгжүүдийг зохион байгуулалт аргазүйн удирдлагаар хангах, ус цаг уур байгаль орчны хяналт шинжилгээг зохион байгуулж, төлөв байдлыг үнэлэх, төр аж ахуйн нэг байгууллага, ард иргэдийг мэдээллээр хангах” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна

Хэнтий аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Цаг уур, орчны шинжилгээний газрын Захиргаа, дотоод аудитын хэлтсээс Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит гүйцэтгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,487.0 сая төгрөгөөс 1 хувиар буюу 14.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 11.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хэнтий аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 71.5 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	
Авлага	0.2	13.8	13.6
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	142.1	113.5	(28.6)
Үндсэн хөрөнгө	415.2	358.8	(56.4)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>557.6</b>	<b>486.1</b>	<b>(71.5)</b>
Өр төлбөр	7.0	-	(7.0)
Засгийн газрын оролцоо	550.7	486.1	(64.5)
Засгийн газрын оролцоо /Өмч - Төрийн/	1,150.0	1,150.0	-
Өмнөх үеийн үр дүн	(720.0)	(720.0)	(0.0)
Тайлант үеийн үр дүн	-	(64.5)	(64.5)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	120.7	120.7	-
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>557.6</b>	<b>486.1</b>	<b>(71.5)</b>

Авлага дансны үлдэгдэл нь жилийн эцэст сумдын Цаг уурын өртөөнд олгосон түлээний үнэ 13.8 сая төгрөгийг шууд зардалд бичсэнийг авлага үүсгэж залруулснаас шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 113.5 сая төгрөг болж 28.6 сая төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 358.8 сая төгрөг болж 56.4 сая төгрөгөөр буурсан нь хуучин барилга, тоног төхөөрөмжийг акталж данснаас хассантай холбоотой.

Өмнөх оны татварын өр 7.0 сая төгрөгийг төлж барагдуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 486.1 сая болж 64.5 сая төгрөгөөр буюу тайлант үеийн үр дүнгээр буурсан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 125.1 сая төгрөгөөр буюу 7.7 хувиар буурсан нь өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна.

~~Нийт зардал өмнөх оноос 5.2 сая төгрөгөөр буюу 0.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа үйлчилгээний бусад байна~~

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 1,237.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 79.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж 1,317.3 сая төгрөгөөр баталсан байна

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,317.3 сая төгрөгийн төсөв баталсныг 1,316.8 сая төгрөгийг улсын төсвөөс, 0.5 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,316.8 сая, үндсэн ажиллагааны орлого 1.1 сая төгрөг, нийт 1,317.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,307.0 сая төгрөгийг зарцуулж 10.9 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн бодон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 0.5 сая, дээд шатны төсвийн захирагчаас 7.6 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 30.8 сая төгрөг нийт 38.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 38.8 сая төгрөгийг зарцуулж 0.1 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.7.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансны сайтад оруулбал зохих 1,464.2 сая төгрөгийн 27 гүйлгээнээс таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын 5.0 сая төгрөгийн 1 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 720.9 сая төгрөгийн 10 гүйлгээ, зарлагын 10.6 сая төгрөгийн 1 гүйлгээ нийт 736.5 сая төгрөгийн 12 гүйлгээг мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

### **3.8 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 8.3 сая төгрөгийн 1 албан шаардлага, 0.5 сая төгрөгийн 4 зөвлөмж өгснөөс Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 зөвлөмжийг биелүүлээгүй байна.

### **3.9 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 767.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 15.8 сая төгрөгийн 3 алдааг санхүүгийн тайланд залруулж, 752.1 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлсэн.

### **4.1. Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Түлээний үнэ 13.8 сая төгрөгийг шууд зардалд бичсэнийг авлага үүсгэж,
2. Хөшигний үнэ 1.7 сая төгрөгийг шууд зардалд бичсэнийг бараа материалын тайланд орлого авхуулж,
3. Үндсэн хөрөнгийн дансанд 0.3 сая төгрөгийн бараа материал бүртгэснийг бараа материал дансанд орлого авхуулж тус тус залруулав.

#### 4.2. Албан шаардлага

Аудитаар залруулагдаагүй 31.4 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Түлш халаалтын зардлаас ахмадын санд түлээ нүүрсний хөнгөлөлт 7.9 сая төгрөгийг шилжүүлж зориулалт бус зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2. МУ-ын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй 7.7 сая төгрөгийг зарцуулсан.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

		/сая төгрөгөөр/									
Д/Д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Хэнтий аймгийн УЦУОШТөв	5	31.4	3	15.8			2	15.6		
Дүн		5	31.4	3	15.8			2	15.6		
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	Хэнтий аймгийн УЦУОШТөв	1	736.5					1	736.5		
Дүн		1	736.5					1	736.5		
Нийт дүн		6	767.9	3	15.8			3	752.1		



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 21

Дугаар 01А2370462  
ХЭА-2022/18/НА-СТА-ТЦЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Түлш халаалтын зардлаас ахмадын санд 7,920.0 мянган төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлтийг шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан зардлыг зориулалт бус зарцуулсан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Хэрлэнчимэг, нягтлан бодогч Г.Нямсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Аудитор

Аудитын менежер

Б.Хуланхатан

Д.Оюунтуяа





ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 21

Дугаар 02 А2370452  
ХЭА-2022/18/НА-СТА-ТШЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны сайтад мэдээлбэл зохих 736.5 сая төгрөгийн 12 гүйлгээг мэдээлээгүй, мэдээллийг хуулийн хугацаанд, үнэн зөв мэдээлж байх гэсэн өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-д "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Хэрлэнчимэг, нягтлан бодогч Г.Нямсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Аудитор

Аудитын менежер

Б.Хуланхатан

Д.Оюунтуяа





ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 21

Дугаар 03-А2370462  
ХЭА-2022/18/НАСТА-ТЦЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар даргах зөрчил илэрлээ. Үүнд:

Батлагдсан төсвийн тэвчиж болох зардлаас 7.7 сая төгрөгийг хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Монгол улсын Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1 дугаар зүйлийн 1.1-д "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах", 1.5 "салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх" гэж заасныг баримталж ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Хэрлэнчимэг, нягтлан бодогч Г.Нямсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Аудитор

Аудитын менежер



Б.Хуланхатан

Д.Оюунтуяа

2317144297  
СИА0046 9074082

023040888